



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/136

Баянхутаг сум

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.5, 4.1, 5.2, Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 27 -ны өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхутаг сумын иргэн Ц.Энхцэцэг нь Улаанбаатар хотод зохион байгуулагдах Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Параволейбол”-ын тэмцээнд хоёр дахь удаагаа, Улсын чанартай тэмцээн уралдаанд гурав дахь удаагаа явах гэж байгаа учир тэмцээний зардалд 200.000 /Хоёр зуун мянга/ төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 200.000 /Хоёр зуун мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг Нягтлан бодогч /Г.Пүрэвдулам/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАЙГАЛМАА